

**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ**
/Human resource management
for forensic science organization/

3.МӨНХ-ЭРДЭНЭ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч

Z.MUNKH-ERDENE

Expert, Department of Forensic Investigations, National Institution of Forensic Science,
Police Senior Lieutenant

Товч агуулга: Байгууллагын үйл ажиллагаа мэдлэг, чадвар, ёс зүйтэй алба хаагчаас шууд хамааралтай. Тэр тусмаа төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хүний нөөцийн менежмент, алба хаагчийг мэргэшлийн асуудал нэн чухалд тооцогддог. Шүүхийн шинжилгээний байгууллагын цаашдын хөгжлийн чиг хандлага нь чадварлаг хүний нөөцөөс шалтгаална. Энэхүү илтгэлд шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч бэлтгэж буй өнөөгийн байдал, оновчтой саналыг судлаачийн зүгээс товч илэрхийллээ.

Abstract: The organization's operations depend on employees' knowledge, skills, and ethics. In particular, the issues of human resource management and employee qualifications in organizations with special government functions are considered important. The direction of further development of forensic organizations depends on skilled human resources. In this report, the current state of forensic expert preparation and the optimal suggestions are briefly discussed.

Түлхүүрүгс: Хүний нөөц, тогтолцоо, шүүхийн шинжилгээ, шинжээч

Key words: Human resources, system, forensic science, expert

Хөгжлийн явцад үр дүнтэй, шинжлэх ухааны үндэслэл бүхий удирдлагын шинэлэг арга туршлагад суурилсан, хувь хүний авъяас, бүтээлч идэвхийг хөгжүүлэх, хөдөлмөрийн оновчтой, үр ашигтай зохион байгуулалт, тухайн байгууллагын хөгжлийн чиг хандлага, стратеги, төлөвлөгөөг тодорхойлох зорилго бүхий цогц үйл ажиллагааны зөв шийдлийг хүний нөөцийн менежмент¹ гэнэ.

Хүний нөөцийн менежмент нь бүхий л байгууллагын чухал асуудал билээ. Цаашид ч ажилтан, алба хаагчдын мэдлэг, ур чадвар, ёс зүй гэсэн асуудлууд нэн чухал байсаар байна.

Аливаа байгууллагын оршин тогтнох, амжилттай ажиллах нь хүний нөөцийг хэр зэрэг зөв бүрдүүлж,

удирдахаас шууд шалтгаална². Хүний нөөцийн ажлыг зөв зохион байгуулах нь ганц шаардлагатай ажилтан, алба хаагчийг бүрдүүлэхээс гадна сонгон шалгаруулах, нөөц бүрдүүлэх, цалин хөлсийг тодорхойлох, бэлтгэх, удирдах албан тушаалтныг бэлтгэх зэрэг олон асуудлууд бий.

Төрийн алба тэр дундаа төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, мэргэжилтэн, ажилтан, алба хаагчдыг засгийн газрын агентлагуудын захиалгаар сургалт, судалгааны нэгжид сургаж бэлтгэх, шаардлагатай мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулалт зарлах замаар судлаж элсүүлдэг.

Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд хүний нөөцдөө ихээхэн анхаарч байгаагийн тод жишээ нь


¹Бурмаа, Н. Нийтийн удирдлагын үндэс.-Уб., 2018. 388 дэхтэл.

²Дорж, Т. Менежмент.-Уб., 2018. 294 дэхтэл.

Дотоод хэргийн их сургуулийн сургалтын хөтөлбөрүүдээс харж болох юм. Жишээлвэл: Хэрэгжүүлж байсан “1+1+1” хөтөлбөр, “мөрдөгч-шинжээч” хөтөлбөр, “цагдаагийн ажил-эрх зүй” бакалаврийн 2 жилийн хөтөлбөр болон бусад дээд боловсролтой иргэдийг сургаж буй хөтөлбөрүүд нь төрийн тусгай албаны хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагаас шууд хамаарч байгааг илтгэж байна. Дотоод хэргийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилийн “Цагдаагийн ажил-эрх зүй” бакалаврийн 2 жилийн хөтөлбөрт Эдийнзасаг, Сэтгэл судлал, Нягтлан бодох бүртгэл, Санхүү, банк, даатгал, Байгалийн ШУ, Математик

статистик, Мэдээлэл харилцаа холбооны технологи, Инженерчлэл, Үйлдвэрлэл, зохион бүтээгч, ХАА мал эмнэлзүй, Цэрэг, батлан хамгаалахын мэргэжил эзэмшсэн байх³ шаардлага нь тухайн агентлаг, байгууллагын хүний нөөцийн судалгаанаас хамаарч тухайн байгууллагад дээр дурьдсан мэргэжилтнүүдийн хэрэгцээ, шаардлага байгаа, мөн өмнө нь их дээд сургууль дээрх мэргэжлээр төгссөн иргэдийг дахин мэргэшүүлэх туршилтын ажил болж байгаа гэж үзэж байна. Энэхүү сургалтын хөтөлбөрөөс гарах үр дүнг схемчлэн харуулвал:

Зураг 1. Сургалтын хөтөлбөрийн үр дүн



Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийг богино хугацаанд, чадвартай, туршлагатай алба хаагч бэлтгэхэд шинэ сургалтын хөтөлбөрүүдийг туршиж үзэх нь байгууллагад ашигтай байж болох юм. Яагаад гэвэл төрийн тусгай албанд дан ганц төрийн тусгайлсан чиг үүрэгтэйгээр бэлтгэгдэхээс гадна хоёр мэргэжилтэй, түүнээс дээш мэргэжилтэй, мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн алба хаагч байх хэрэгцээ шаардлага бий. Тийм учраас хүний нөөцийн бодлогод богино хугацаанд, чадвартай, туршлагатай алба хаагч бэлтгэхэд суурь мэргэжлийг ямар байвал үр дүн сайтай эсвэл хосолсон хөтөлбөр бий болгох гэх мэтийн

сургалтын туршилтуудыг ашиглаж үзэх нь зөв арга гэж үзэж байна. Үүний тод жишээ бол Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, ахисан шатны боловсрол олгох явдал юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд бие даасан хуультай, хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч, мэргэжилтнээр оролцож дүгнэлт гаргах үүрэг бүхий шинэхэн бэхжиж буй төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

³Дотоод хэргийн их сургуулийн 2022-2023 оны бакалаврын элсэлтийн журам.

Шинжээчийн бусад мэргэжилтнээс ялгарах гол онцлог бол тэд “тусгай мэдлэг” эзэмшсэн явдал юм¹. Тусгай мэдлэг эзэмшсэн байх нь хуульд заасан үндсэн 2 чиг үүргийн нэгийг хэрэгжүүлэхэд зайлшгүй тавигдах шаардлага юм. Шинжээчийн чиг үүргийг ерөнхийд нь 2 ангилж болно. Нэгдүгээрт; хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий алба хаагчийншийдвэр, тогтоол, захирамжийн дагуу шинжилгээ хийж дүгнэлт гаргах, хоёрдугаарт; хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд мэргэжилтнээр оролцох юм.

Манай улсын хувьд түүхийн хугацаанд 1964 оноос эхлэн ЗХУ одоогийн ОХУ-д криминалистикийн шинжээч нарыг бэлтгэсээр ирсэн бөгөөд одоо ч бакалавр болон ахисан түвшинд бэлтгэхэд хамтран ажилласаар байгаа билээ. Харин дотооддоо 2003 оноос албан ёсоор “Эрх зүйч-Криминалистикийн шинжээч” мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн байна. Одоогоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь ДХИС-ийн Шинжлэн магадлахуйн институттэй хамтран криминалистикийн шинжээч бэлтгэх, боловсролын зэрэг ахиулах ажлыг зохион байгуулан явуулж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээч бэлтгэх ажлыг Дотоод хэргийн их сургуультай хамтран зохион байгуулдаг. Харин Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн одоогийн бүтцээр тусгай мэдлэг бүхий шинжээчийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Криминалистикийн шинжээч;
- Тусгай шинжилгээний газрын шинжээч/ биологи, физик, хими, ДНК, бактерлогийн шинжээч/;
- Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын шинжээч эмч;

- Экологийн шинжилгээний газрын шинжээч.

Шинжээч бэлтгэх сургалтын тогтолцоо гэдэг нь шинээр элсүүлэх, сургах, төгсгөх, давтан сургах, шинжилгээ хийх эрх олгох, боловсролын зэрэг ахиулах гэсэн хоорондын уялдаа бүхий боловсрол, зохион байгуулалтын цогц ойлголт юм².

Криминалистикийн шинжээч бэлтгэж буй тогтолцоо нь бакалаврын элсэлтээр иргэнийг суралцуулахаар элсүүлэх, сургах, төгсгөх, боловсролын зэрэг ахиулах сургалтанд хамруулах замаар явагдаж байгаа юм. Криминалистикийн шинжээч нь тодорхой чиглэлээр мэргэшдэг. Энэ нь Криминалистикийн шинжлэх ухааны хувьд боловсон хүчнээс олон төрлийн ур чадвар, мэдлэг, туршлага шаардсан байдаг.

Шинжлэн магадлах үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудал нь үнэн хэрэгтээ хэргийн бодит үнэнийг тогтооход тусгай мэдлэг ашиглах тогтолцоог боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэж байна.³

Судлаач хууль зүйн доктор Т.Очирбатын хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээлд шинжлэн магадлах ухааны тогтолцоог дараах байдлаар хураангуйлж авч үзэх санал дэвшүүлжээ. Үүнд:

1. Шинжлэн магадлахуйн ерөнхий онол;
2. Шинжлэн магадлахуйн эрх зүй;
3. Шинжлэн магадлахуйн зохион байгуулалт;
4. Шинжлэн магадлахуйн технологи.

¹ Лхагвасүрэн, Б. Шинжлэн магадлах ухаан. – УБ., 2018. 190 дахь тал.

² Лхагвасүрэн, Б. Шинжлэн магадлах ухаан. – УБ., 2018. 157 дахь тал.

³ Очирбат, Т. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. – УБ., 2019.

Харин зохион байгуулалтын асуудлыг бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваан авч үзсэн байна. Үүнд:

- Процессын өөр өөр хэлбэрт явагдах магадлах шинжилгээний зохион байгуулалт;
- Шинжлэн магадлах үйл ажиллагааны дэд бүтэц;
- Шинжээч бэлтгэх үйл ажиллагаа. Үүнээс харвал шинжээч бэлтгэх асуудал нь бусад судлаачдын бүтээлд тусгагдсаныг харж болно.

Практикт Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын бүтэц нь тодорхой чиглэл, мэргэшлийн дагуу байхаар зохион байгуулагдсан байдаг. Жишээлбэл: Галт зэвсгийн шинжилгээний лаборатори, Бичиг баримтын шинжилгээний лаборатори, Мөр судлалын шинжилгээний лаборатори, Гэрэл зураг, дүрс бичлэг, дүрс зургийн шинжилгээний, Авто техникийн шинжилгээний лаборатори гэх мэт. Хүний нөөцийн хэрэгцээ шаардлагаар бол тодорхой чиглэлийн мэргэшсэн шинжээчийг бэлтгэхэд зарим зүйлсийг анхаарах шаардлага урган гарч ирж байгаа юм. Юу вэ гэвэл тодорхой чиглэлийн криминалистикийн шинжээч нь хоёроос болон түүнээс дээш бакалаврын боловсролын зэрэгтэй дүйцэхүйц мэдлэгтэй байхыг шаардаж байгаа явдал юм. Харин эдгээр мэргэжлийн дагуу хэрхэн богино хугацаанд алба хаагчийг сургаж мэргэшүүлэх, суурь мэргэжил нь аль нь байвал байгууллагад ашигтай байх зэрэг асуудал нь хүний нөөцийн бодлогоор тодорхойлогдох юм.

Мэдээж ийм сургалтыг зохион байгуулна гэвэл цаг хугацааны хувьд алдагдалтай боловч хүний нөөцийн бодлогоор сургалтын хөтөлбөр эсвэл байгууллагын захиалгаар бэлтгэгдэх боломжтой гэж үзэж байна. Үүнээс үзэхэд криминалистикийн шинжлэх ухаан нь олон шинжлэх ухааны уулзвар дээр байх зангилаа шинжлэх ухаан гэж хэлж болохоор байна. Гэхдээ зөвхөн криминалистикийн шинжээчийг бэлтгэх

асуудлаар хязгаарлагдахгүйгээс гадна бусад чиглэлийн тусгай мэдлэг бүхий шинжээчийг бэлтгэх асуудал нь өөр өөрийн гэсэн онцлогтой юм.

Дээрх байдлаар судлах нь олон талт хэрэгцээ, шаардлагаас гадна төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын хувьд аливаа болзошгүй эрсдлээс урьдчилсан сэргийлэх, бэлтгэлтэй байх явдал гэж судлаачийн зүгээс бодож байна. Жишээлбэл: Байлдааны, цэргийн зэвсэглэл нь галт зэвсгийн тухай хуулиас тусдаа эрх зүйгээр зохицуулагддаг ч гэсэн энэ төрлийн зэвсэглэлээр гэмт хэрэг үйлдэгдэхийг үгүйсгэх аргагүй билээ.

Мэргэжил эзэмших болон мэргэшүүлэх гэсэн ойлголтыг тайлбарлахыг оролдвол: Мэргэжил бол бакалаврын хөтөлбөрөөр сургалтанд хамрагдаж эзэмшсэн мэдлэгийг хэлэх бол мэргэшлийн хувьд гүнзгийрүүлэх, туршлагжих ойлголтыг илэрхийлж болох юм. Мэргэшлийн хувьд тухай мэргэжлийн ажлыг эрхэлсэн, нэмэлт сургалтанд хамрагдаж бий болгосон мэдлэгийг хэлж боломж юм. Түүнээс гадна чанартай, ёс зүйтэй, мэдлэг, ур чадвартай алба хаагч бэлтгэхэд сургалтын хөтөлбөр боловсруулах замаар судлаж болох юм. Үүнд: суурь мэргэжил ямар байвал үр дүн сайн байна гэдгийг судлаж болох юм. Дээрх байдлаар алба хаагчийг бэлтгэх, мэргэшүүлэх нь цаашид шинжлэх ухааны туршилт, судалгаа хийхэд саад учрахгүйгээр олон талт мэдлэгтэй мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэж болох юм гэж үзэж байна.

Дүгнэлт

Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийн бодлого олон зүйлээс шалтгаалах юм. Алба хаагчийн ёс зүй, мэдлэг, чадвар, туршлага, ур чадвар, боловсрол гээд нийгмээс, хувь хүнээс шалтгаалах хүчин зүйлсээс хамаарна гэж үзэж байна. Тэдгээрийн дотроос албаны мэргэжлийн онцлог, чиглэлээс шалтгаалж алба хаагчийн мэргэжлийн ур чадварт боловсрол хэрхэн нөлөөлж болох тэр

дундаа шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч бэлтгэх тогтолцооны талаар илтгэлдээ товч илэрхийллээ.

Шинжээч бэлтгэх тогтолцоо нь захиалагч байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөтөлбөрийн дагуу явагдах боловч мэргэжлийн бодит тулгарч буй хэрэгцээ, шаардлага байна гэж үзлээ. Энэ нь аливаа туршилт, судалгааг шинжлэх ухааны үндэстэй туршихад шинжээчийн зүгээс саадгүй ажил явуулах нэг талын нөхцөл болох юм гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий зарим байгууллага ч хүний нөөцийн боловсролыг төлөвлөх, алба хаагчийн ажил үүрэг гүйцэтгэх, чадваржих нөхцөл

байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгааг сургалт, судалгааны төвийн элсэлтийн журам, бэлтгэгдэж буй суралцагчидаас харж болох юм.

Эх сурвалжийн жагсаалт

- Бурмаа Н. Нийтийн удирдлагын үндэс.УБ., 2018
- Дорж Т.Менежмент. УБ., 2018
- Лхагвасүрэн Б. Шинжлэн магадлах ухаан.УБ., 2018
- Очирбат Т. “Шинжлэн магадлахуйн онол, эрхзүй, зохион байгуулалтын асуудал”. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. ДХИС. УБ., 2019.